



ЭРҮҮДЭН ШҮҮХТЭЙ ТЭМЦЭХ НЬ

ХУУЛЬ САХИУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД АШИГЛАХ ТУСГАЙ ХЭРЭГСЛИЙН
ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА



Omega Research Foundation

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



Эмнести Интернэшнл бол хүн бүр эрхээ эдэлдэг дэлхийн ертөнцийг бий болгохын төлөө 7 сая гаруй гишүүд, дэмжигчдийг эгнээндээ нэгтгэсэн даян дэлхийн хөдөлгөөн юм.

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон хүний эрхийн олон улсын хэм хэмжээгээр хамгаалагдсан бүхий л эрхийг хүн бүрд эдлүүлэх нь бидний эрхэм зорилго билээ.

Бид төр засгийн аливаа байгууллага, улс төрийн үзэл хандлага, эдийн засгийн эрх ашиг болон шашны үзлээс бүрэн ангид, хараат бүс байгууллага бөгөөд гишүүд дэмжигчид хийгээд олон нийтийн хандив, дэмжлэгээр санхүүждэг болно.

Омега Судалгааны Сан нь цэрэг, аюулгүй байдал болон цагдаагийн үйл ажиллагаанд хэрэглэх тусгай хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа, ашиглалтыг судлах зорилготой Их Британид төвтэй бие даасан судалгааны байгууллага юм.

©Эмнести Интернэшнл 2018

Энэ сэтгүүлд тусгагдсан бүтээлүүд Бүтээлч Хамтын Өмчид харьяалагдана. (зохиогчийн нэрийг дурдана, худалдахгүй, хуулбарлахгүй, олон улсын 4.0 зөвшөөрөл)
<https://creativecommons.org/licenses/by-nc-nd/4.0/legalcode>

Дэлгэрэнгүй мэдээллийг манай цахим хуудсаас авна уу:
www.amnesty.org

Зохиогчийн эрхийг Эмнести Интернэшнл хэмээн заагаагүй тохиолдолд Бүтээлч Хамтын Өмчийн зөвшөөрөл олгохгүй.
2018 онд анхлан хэвлэгдэв.
Amnesty International Ltd
Ийстон Гудамж 1, Петер Бененсоны Ордон
Лондон хот WC1X 0DW, UK



Cover design: A close up of a direct contact electric shock device
© Amnesty International. Design by Colin Foo

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Индекс: АСТ/30/9039/2018

Эх хэвлэлийн хэл: Англи

amnesty.org

**ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ**



АГУУЛГА

1. ОРШИЛ	2
2. ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН	4
3. ХОРИГЛОСОН БОЛОН ХЯНАЛТТАЙГААР ХЭРЭГЛЭХ ЗЭВСЭГ, ХЭРЭГСЭЛ	6
3.1 ХОРИГЛОХ ШААРДЛАГАТАЙ ТУСГАЙ ХЭРЭГСЛҮҮД	8
3.1.1 ЦАХИЛГААН ГҮЙДЛЭЭР ЦОХИГЧ ЗЭВСЭГ, ХЭРЭГСЭЛ	8
3.1.2 МЕХАНИК ХЯЗГААРЛАЛТЫН ХЭРЭГСЛҮҮД	10
3.1.3 КИНЕТИК НӨЛӨӨЛӨЛ БҮХИЙ ЗЭВСЭГ, ХЭРЭГСЭЛ	13
3.1 ХЯНАЛТТАЙГААР ХЭРЭГЛЭВЭЛ ЗОХИХ ТУСГАЙ ХЭРЭГСЛҮҮД	14
3.1.1 ЦАХИЛГААН ГҮЙДЛЭЭР ЦОХИГЧ ЗЭВСЭГ	14
3.1.2 МЕХАНИК ХЯЗГААРЛАЛТЫН ХЭРЭГСЛҮҮД	15
3.1.3 КИНЕТИК НӨЛӨӨЛӨЛ БҮХИЙ ЗЭВСЭГ, ХЭРЭГСЭЛ	18
3.1.4 ОЛОН ХҮНД ХЭРЭГЛЭХ ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ	20
4. СУРГАЛТ БОЛОН ТЕХНИКИЙН ЗӨВЛӨГӨӨ	23
5. ДҮГНЭЛТ	24

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

1. ОРШИЛ

Хүн эхээс төрөхдөө эрүүдэн шүүгч болж төрдөггүй, харин тэд ямар нэгэн зүйлээс сэдэл авч, хэн нэгнээс суралцаж, өдөөгдөж, бэлтгэгдэж байдаг. Олонх тохиолдолд энэ нь эрүүдэн шүүх болон зүй бусаар хандахад ашиглах албадлагын хэрэгслийг үйлдвэрлэж, ханган нийлүүлж байгаа гадаадын компани, аль нэг улсын засгийн газар болон дээрх хэрэгслийг өндөр төвшинд эзэмшсэн мэргэжилтнүүдтэй холбоотой байх нь бий. Нэг хэсэг улс нь дээрх зүй бус худалдаанд шууд хамааралтай байхад, нөгөө хэсэг улс нь мэдсэн ч мэдээгүй дүр эсгэдэг.

Эрүүдэн шүүх хэрэгслийн зарим нь мөн чанарын хувьд туйлын харгис бөгөөд эдгээрийг хэрэглэх нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар харьцаж шийтгэж байгаа үйлдэлд ямар ч эргэлзээгүйгээр хамаарна. Эдгээрт дундад зууны үед түгээмэл хэрэглэж байсан хөлний дөнгө, хүзүүний гав, өргөст бороохой, төмөр гинж болон ташуур, түүнчлэн эдүгээ бидний үед хэрэглэж байгаа хүчтэй өвтгөх зориулалт бүхий орчин үеийн хэрэгсэл гэгдэх цахилгаан бороохой, цахилгаан гүйдлээр цохигч буу, бүс зэргийг нэрлэж болно. Эдгээр хэрэгслийг хууль сахиулах үйл ажиллагаанд ашиглахыг бүрэн хориглох нь зүйтэй. Харин нулимс асгаруулагч хий болон цацлага, гав зэргийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн зохистойгоор хэрэглэхийг зөвшөөрч болно. Гэхдээ эдгээрийг хүнийг эрүүдэн шүүх болон бусад байдлаар зүй бус хэрцгий хандах зорилгоор ашиглаж байдгийг санах хэрэгтэй. Тиймээс дээрх хэрэгслийн худалдаа, ашиглалтад хуулийн чанга хатуу зохицуулалт шаардлагатай.

Сүүлийн жилүүдэд дэлхийн олон улс үндэстэн эрүүдэн шүүх хэрэгслийн худалдааг хориглон хязгаарлах дотоодын болон бүс нутгийн эрх зүйн зохицуулалтыг хөгжүүлэх чиглэлд ахиц дэвшил гаргасаар байна. Үүнд Европын холбооны жишээг дурдаж болно.¹ Дээрх зорилгын хүрээнд 2017 оны 9 дүгээр сарын 18-ний өдөр Эрүү Шүүлтийн хэрэгслээс ангид худалдааг дэмжих Дэлхийн Холбоо байгуулагдсан бөгөөд эдүгээ тив дэлхийн 60 гаруй улс² “Эрүү шүүлт, цаазын ялыг гүйцэтгэхэд ашигладаг хэрэгслээс урьдчилан сэргийлэх, хязгаарлах, хориглох” болон “дээрх хэрэгслийн худалдааг хориглон хязгаарлах үр нөлөөтэй эрх зүйн механизмыг бий болгох” зорилго бүхий Бодлогын Тунхаглалд гарын үсэг зуржээ.³

Эмнести Интернэшл болон Омега Судалгааны Сан нь дээрх санаачлагыг сайшаан дэмжиж байгаа бөгөөд дэлхийн олон улс энэхүү бодлогыг хөхиүлэн дэмжихийг уриалж байна. Дэлхийн Холбоо нь эрүү шүүлтийн хэрэгслийн худалдаатай тэмцэх үндэсний болон олон улсын түвшний үр нөлөө бүхий механизмыг хөгжүүлэх, дэмжих чиглэлд хангалттай нөөц бололцоотой болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Гэвч, үр нөлөөтэй механизмыг бий болгоход эрүүдэн шүүх болон хүнлэг бус хэрцгий хандах, хүч албадлагыг хэтрүүлэн ашиглаж хүний эрхийг бүдүүлгээр зөрчин тарчлаах, зовооход өргөнөөр ашиглаж байгаа хэрэгслийн талаарх иж бүрэн тодорхойлолтыг улс

1 2005 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 1236/2005 тоот Зөвлөлийн Журамд “цаазаар авах болон эрүүдэн шүүх, хүнлэг бус хэрцгий хандах, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхэд ашиглах зарим хэрэгсэл”-ийн худалдааны асуудлыг тусгайлан авч үзсэн. Энэхүү журам 2006 оны 7 дугаар сарын 31-ний өдөр хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бөгөөд хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт орсон. Европын Холбооны Эрүүдэн Шүүх Хэрэгслийн Худалдааны Зохицуулалт нь цаазаар авах ял болон эрүү шүүлт, хүнлэг бус, хэрцгий хандах зорилгоор ашиглах тусгай хэрэгслийн олон улсын худалдааг хориглог, хяналтын асуудлыг зохицуулж, хүний эрхийг ноцтойгоор зөрчихөд ашиглах болох хэрэгслийн худалдааны тусгай зөвшөөрлийн шаардлага зэргийг авч үзсэн нь дэлхийн хэмжээнд анхдагч болсон юм.

2 Дэлхийн Холбооны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах сайтаас авна уу. <http://www.torturefreetrade.org/>

3 Эрүү шүүлт болон цаазын ялын зорилгоор ашиглах хэрэгслийн худалдааг эцэс болгох Дэлхийн Холбоо, Бологын Тунхаглал, Нью Йорк хот, 2018 оны 9 дүгээр асрын 18-ны өдөр, http://www.torturefreetrade.org/documents/170918_Political-Declaration-Torture-Free.pdf

үндэстнүүд хүлээн зөвшөөрөх нь чухалд тооцогдож байна. Энэ нь хурууны гав, өргөст бороохой, цахилгаан гүйдлээр цохигч бүс зэрэг туйлын харгис хэрэгслүүдийг үйлдвэрлэх, ашиглахыг бүрэн хориглохоос гадна бороохой, гав, нулимс асгаруулагч хий, чинжүүтэй цацлага зэргийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэхийг хүлээн зөвшөөрсөн хэдий ч эрүү шүүлт тулгаж, хүний эрхийг ноцтойгоор зөрчихөд ашиглаж болох ердийн тусгай хэрэгслийн ашиглалтад үр нөлөөтэй хяналтын тогтолцоог бий болгох асуудал мөн хамаарна.

Европын Холбооны Эрүүдэн шүүх хэрэгслийн худалдааны эсрэг зохицуулалт нь дээрх хэрэгслийг үндсэн хоёр төрөлд ангилан авч үзжээ. Эдгээрт:

- i. Мөн чанарын хувьд туйлын харгис бөгөөд худалдаалах, ашиглахыг бүрэн хориглосон хэрэгслүүд
- ii. Хууль сахиулах үйл ажиллагаанд ашиглах хэдий ч эрүү шүүлт, болон хүнлэг бус, хэрцгий хандах, цаазын ялыг гүйцэтгэхэд ашиглах явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор худалдаанд тусгай хяналт тавибал зохих хэрэгслүүд зэрэг болно.

Хууль сахиулах үйл ажиллагаанд ашиглах зэвсэг, хэрэгслийг хүнийг эрүүдэн шүүх, хүнлэг бус хэрцгий хандах болон хүний эрхийг бусад байдлаар ноцтойгоор зөрчих зорилгоор хэрэглэхийг бүрэн хориглоно. Хэдийгээр дээрх зарчим нь тодорхой улс, бүс нутгийн байгууллагуудын бодлогын баримт бичигт хэдийнээ хүлээн зөвшөөрөгдөж, тусгалаа олсон хэдий ч олон улсын эрх зүйн зохицуулалтын бүрэн бус байдал, хийдлийг тэргүүн ээлжинд засварлах шаардлагатай байна. Эрүү шүүлтийн хэрэгслийн худалдааг хориглох талаарх улс орнуудын бодлого, эрх зүйн зохицуулалтын алдаа, үр нөлөөтэй хяналтын механизмын дульмаг байдал нь дэлхийн хүний эрхэд аюул учруулж байна.

Эмнести Интернэшнл болон Омега Судалгааны Сан нь Эрүүдэн шүүх хэрэгслээс ангид худалдааг дэмжих Дэлхийн Холбооны гишүүн улсууд болон дэлхийн бусад улс орныг эрүүдэн шүүх хэрэгслийн худалдааг үр нөлөөтэй шийдвэрлэх иж бүрэн механизмыг бий болгох чиглэлд дараах арга хэмжээ авахыг уриалж байна.

- Хуулийг албадан хэрэгжүүлэхэд ашиглагдаж байгаа туйлын харгис гэгдэх аливаа хэрэгслийн үйлдвэрлэлийг бүрэн хориглосон хууль тогтоомжийг батлах
- Эрүүдэн шүүх болон хүнлэг бус хэрцгий хандахад ашиглах боломжтой хэрэгслийн эргэлтийн талаарх худалдааны зохицуулалтыг батлах, хатуу хяналтын механизмыг бий болгох, хүний эрхэд үндэслэсэн эрсдэлийн үнэлгээг хийх
- Эрүүдэн шүүх хэрэгслийн худалдааны талаар бүс нутгийн болон олон улсын зохицуулалтыг бий болгох талаар хэлэлцэн тохиролцож холбогдох мэдээллийг солилцох, тайлагнах ил тод тогтолцоог бий болгох

**ЭРҮҮДЭН ШҮҮХ ХЭРЭГСЛИЙН ХУДАЛДААГ
ХОРИГЛОХ УЛС ОРНУУДЫН БОДЛОГО,
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ АЛДААТАЙ,
ҮР НӨЛӨӨТЭЙ ХЯНАЛТЫН МЕХАНИЗМ
БАЙХГҮЙ БАЙГАА НЬ**



ДЭЛХИЙН ХҮНИЙ ЭРХИЙН БАЙДАЛД АЮУЛ УЧРУУЛЖ БАЙНА.

2. ЭРХ ЗҮЙН ОРЧИН

ЭРҮҮДЭН ШҮҮХИЙГ ХОРИГЛОСОН НЬ

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх үйлдлийг олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр бүрэн хориглосон бөгөөд ямар ч тохиолдолд, тухайлбал зэвсэгт мөргөлдөөн, террорист халдлагын эсрэг ажиллагаа болон нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед ч эрүүдэн шүүхийг хориглодог. Дээрх зохицуулалт нь олон улсын эрх зүйн үндсэн зарчим бөгөөд тухайн улс холбогдох олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орсон эсэхээс үл хамааран заавал биелүүлэх шинжтэй хэм хэмжээ юм. Өөрөөр хэлбэл, дээрх хүний эрхийн хамгаалалтыг ямар ч хэлбэрээр үгүйсгэх боломжгүй. Төр нь аливаа төрийн албан хаагч эрх мэдлээ урвуулан ашиглаж хүнийг эрүүдэн шүүх, хүнлэг бусаар харьцах явдлаас урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ, хувь хүн, бүлэг болон хуулийн этгээдийн дээрх хууль бус үйлдлийн улмаас хүний эрх зөрчигдөх явдлаас хамгаалах үүрэгтэй. Эрүүдэн шүүх бүх үйлдэл нь олон улсын хэм хэмжээний дагуу гэмт хэрэг бөгөөд ийм гэмт хэрэг үйлдэгчид эрүүгийн хуулийн дагуу зохих шийтгэл ногдуулах нь төрийн үүрэг хариуцлага юм. Хүнийг бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар харьцаж, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх зарим төрлийн үйлдлийг олон улсын эрх зүйн зохицуулалтын дагуу гэмт хэрэг хэмээн үздэг.

Хүчирхийллийн зэвсэг, хэрэгсэл ашиглах болон түүнийг худалдаалахыг үндэсний хууль тогтоомжоор хориглосноор улс орны төр, засгийн газар хуулийг албадан хэрэгжүүлэхэд ашигладаг хэрэгслийн эргэлтэд хүний эрхийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн эрсдэлийн үнэлгээг хийж эхлэхийн зэрэгцээ эрүүдэн шүүх болон бусад хүнлэг бус үйлдэлтэй тэмцэх талаарх олон улсын эрх зүйн хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь дэмжлэг болох болно.

Төр нь аливаа төрийн хаагч албаны эрх мэдлээ урвуулан ашиглаж хүнийг эрүүдэн шүүх, хүнлэг бусаар харьцах явдлаас урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ, хувь хүн, бүлэг болон хуулийн этгээдийн дээрх хууль бус үйлдлийн улмаас хүний эрх зөрчигдөх явдлаас хамгаалах үүрэгтэй.



**СЭЖИГТЭН БОЛОН ХОРИХ ГАЗАРТ ЯЛ ЭДЭЛЖ
БАЙГАА ХҮНИЙ ЭРХИЙГ ХҮНДЭТГЭЖ,
ХАМГААЛАХ НЬ ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ТӨРИЙН АЛИВАА
БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ МӨН.**

АЛБАДЛАГЫГ ХУУЛЬ ЁСНЫ ДАГУУ ХЭРЭГЛЭХ НЬ

Олон улсын эрх зүйн амин чухал үнэт зүйл болсон амьд явах эрх болон эрүү шүүлтээс ангид байх эрхийг төр хүндэтгэн, хамгаалах нь үгүйсгэж үл болох үндсэн үүрэг юм. Хуулиар эрх олгогдсон төрийн албан хаагч нь хууль сахиулах зорилгоор хүч, албадлагыг хэрэглэх бөгөөд зөвхөн зайлшгүй тохиолдолд, тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэглэх үүрэгтэй.

Хууль сахиулах байгууллагаас хүч, албадлага хэрэглэхтэй холбоотой харилцааг 1979 онд батлагдсан “Хууль сахиулах байгууллагын албан хаагчийн баримтлах ёс зүйн дүрэм”⁴, 1990 онд батлагдсан “Хууль сахиулах байгууллагаас хүч, албадлага болон зэвсэг, хэрэгсэл ашиглах НҮБ-ын үндсэн зарчим”⁵ зэрэг олон улсын хэм хэмжээгээр зохицуулдаг. Дээрх баримт бичигт зааснаар хуульд заасан хүч албадлагыг зөвхөн хуулиар эрх олгогдсон, зохих сургалтад хамрагдсан, хариуцлагатай төрийн албан хаагчид хуульд заасан нөхцөл, журмын дагуу хэрэглэх бөгөөд асуудлыг хуульд заасан хүчирхийллийн бус арга хэрэгслээр үр нөлөөтэй зохицуулах боломжгүй тохиолдолд хуулийн дагуу, гарцаагүй тохиолдолд, тухайн нөхцөл байдалд тохируулан хүч албадлагыг хэрэглэнэ.

Цагдан хоригдож байгаа хүн эрүү шүүлтэд өртөх хамгийн өндөр эрсдэлтэйд тооцогддог. Сэжигтэн болон хорих ял эдэлж байгаа этгээдийн эрхийг хүндэтгэж, хамгаалах нь олон улсын эрх зүйн дагуу төрийн хүлээсэн үгүйсгэж үл болох үүрэг бөгөөд цагдан хорих газрын холбогдох албан хаагч нь хүч албадлага хэрэглэхдээ хуульд заасан нөхцөл бүрдсэн эсэх, тухайн нөхцөл байдалд тохирсон эсэхийг сайтар ухамсарлан олон улсын эрхзүйн зарчмыг хүндэтгэх үүрэгтэй. НҮБ-аас баталсан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм” (Нелсон Манделагийн дүрэм гэх)⁶-д хорих газарт хязгаарлалтыг ашиглахад баримтлах зарчим болон процессын журмыг тодорхойлжээ. Уг дүрмийн 82 дугаар зүйлд “Хорих газрын албан хаагчид нь өөрийгөө хамгаалах, хоригдол оргон зугтаахыг завдсан, эсхүл хууль тогтоомжид нийцсэн тушаалыг биелүүлэхээс бие махбодийн идэвхтэй болон идэвхгүй эсэргүүцэл үзүүлснээс бусад тохиолдолд хоригдолд хүч хэрэглэхийг хориглоно. Хүч албадлагыг зөвхөн гарцаагүй тохиолдолд хэрэглэнэ” хэмээн заасан байдаг.

4 Хууль сахиулах байгууллагын албан хаагчийн баримтлах ёс зүйн дүрэм, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1979 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн 34/169 тоот тогтоолоор баталсан.

5 Хууль сахиулах байгууллагаас хүч албадлага болон зэвсэг, хэрэглэх ашиглах НҮБ-ын үндсэн зарчим, Гэмт хэрэгтэй тэмцэх болон гэмт хэрэгтнүүдтэй харьцах асуудлаарх НҮБ-ын наймдугаар чуулга уулзалт, Куба, Гавана, 1990 оны 8 дугаар сарын 27-ны өдрөөс 9 дүгээр сарын 7.

6 1955 онд зохиогдсон Гэмт хэргийн асуудлаар НҮБ-ын чуулга уулзалтаас баталсан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 2010 онд дахин шинэчилсэн. Энэхүү дүрмийг хожим 2015 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон Эрүүгийн шүүхийн асуудлаарх НҮБ-ын комиссоос дахин шинэчлэн батлахдаа Манделагийн дүрэм хэмээн нэрлэх болсон.

3. ХОРИГЛОСОН БОЛОН ХЯНАЛТТАЙГААР ХЭРЭГЛЭХ ЗЭВСЭГ, ХЭРЭГСЭЛ

Цагдаагийн тусгай хэрэгслийн худалдааны талаарх олон улсын эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаагаас үүдэн хүний эрх, эрх чөлөө ялангуяа хүний амьд явах эрх, халдашгүй байх, эрүү шүүлт болон бусад хүнлэг бус, хэрцгий хандах явдлаас ангид байх эрх чөлөө зөрчигдөж байгааг харгалзан үзэж эрүү шүүлтийн хэрэгслийн эргэлтэд тавих хатуу хяналтын механизмыг бий болгох шаардлагатай байна.

Эмнести Интернэшнл болон Омега Судалгааны сан нь дээрх худалдааны асуудлыг үр дүнтэй хуульчлан зохицуулахын тулд дараах үндсэн хоёр аргыг давхардуулан ашиглах боломжтой хэмээн үзэж байна.

- i. Зүй бус хүчирхийллийн зорилгоор ашиглаж байгаа хэрэгслийн үйлдвэрлэл, сурталчилгаа болон худалдааг бүрэн хориглох
- ii. Хууль сахиулах үйл ажиллагаанд хэрэглэх зориулалттай хэдий ч эрүүдэн шүүх болон хүнлэг бус, хэрцгий хандах зорилгоор түгээмэл ашигладаг хэрэгслийн ашиглалтад тавих хяналтыг чангатгах

Тухайлбал, хөлний гав, цахилгаан гүйдлээр цохигч бүс болон гарын эрхий хурууны гав зэргийн үйлдвэрлэл, борлуулалт, ашиглалтыг хуулиар бүрэн хориглох шаардлагатай бол бороохой, нулимс асгаруулагч хий, ердийн гав зэрэгт хяналт тавих хэрэгтэй. Дараах хүснэгтээс бүрэн хориглох, эсхүл хяналт тавих шаардлагатай хэрэгслийн талаарх мэдээллийг харна уу.

ЦАХИЛГААН
ГҮЙДЛЭЭР
ЦОХИГЧ
ХЭРЭГСЭЛ

МЕХАНИК АРГААР
ХЯЗГААРЛАГЧ

ОЛОН НИЙТЭД
НӨЛӨӨЛӨХ
ХЭРЭГСЭЛ

КИНЕТИК НӨЛӨӨЛӨЛ
БҮХИЙ ЗЭВСЭГ, ХЭРЭГСЭЛ

ЦАХИЛГААН ГҮЙДЛЭЭР ЦОХИГЧ БУУ, ХЭРЭГСЭЛ	МЕХАНИК АРГААР ХЯЗГААРЛАГЧ	КИНЕТИК НӨЛӨӨЛӨЛ БҮХИЙ ЗЭВСЭГ, ХЭРЭГСЭЛ	ОЛОН ХҮНД НӨЛӨӨЛӨХ ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ
---	----------------------------	---	--

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ БОЛОН ОМЕГА СУДАЛГААНЫ САНГИЙН ЗҮГЭЭС ХОРИГЛОХ ШААРДЛАГАТАЙ ХЭМЭЭН ҮЗЭЖ БАЙГАА ХЭРЭГСЭЛҮҮД

Цахилгаан гүйдлийн нөлөөгөөр шууд хүчтэй цочроох хэрэгслүүд: цахилгаан бороохой, цахилгаан бамбай, цахилгаан гүйдлээр цохигч буу, цахилгаан бээлий	Хоёр гарын эрхий хуруу болон бусад хурууны гав Гарын эрхий хуруу болон бусад хурууны дөнгө Хөлний дөнгө Хүний гар эсхүл хөлийг эх биетэй холбон хөдөлгөөнийг бүрэн хязгаарлагч Дөнгөлсөн хөлийг гинжээр эх биетэй холбож явах хөдөлгөөнийг хязгаарлагч	Хүчжүүлсэн ташуур болон саваа Өргөст бороохой болон бусад өргөст зэвсэг, хэрэгсэл Хүндрүүлсэн бороохой болон бээлий	Мөн чанарын хувьд харгис гэгдэх хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл
Хүний биед бэхлэн цахилгаан гүйдлээр цочроох хэрэгслүүд: цахилгаан гав, цахилгаан бүс, цахилгаан ханцуйвч, цахилгаан хантааз	Хүзүүний дөнгө Хөдөлгөөн хязгаарлагч олон үйлдэлт хэрэгсэл /метал/ Биеийн хөдөлгөөнийг бүрэн хязгаарлаж сандал, ор болон бусад бэхлэгдсэн эд зүйлд хүлэгч Хүний биеийн эх бие болон дөрвөн мөчийг бүрэн хүлж хөдөлгөөнийг хязгаарлагч Гяндан ор болон төмөр сараалж бүхий хөдөлгөөн хязгаарлагч ор Хоригдлын толгойд углах уут, нүд боогч		

АШИГЛАЛТАД ХЯНАЛТ ТАВИХ ШААРДЛАГАТАЙ ХЭРЭГСЭЛ

Цахилгаан гүйдлээр цохигч	Гарын ердийн гав болон гарын хөдөлгөөнийг хязгаарлагч бусад хэрэгсэл Хөлийн гав болон хөлний хөдөлгөөнийг хязгаарлагч бусад хэрэгсэл Эмнэлгийн зориулалтаар ашиглагдах хөдөлгөөн хязгаарлагч хэрэгсэл, тухайлбал, хөдөлгөөн хязгаарлагч сандал, ор болон бусад тавцан	Гартаа барих зориулалт бүхий хэрэгслүүд, ердийн бороохой, цохиур, Т-бороохой Кинетикийн нөлөөлөл бүхий зэвсэг, үрлэн болон резин сум	Нулимс асгаруулагч (CS, CN, болон CR) Нулимс асгаруулагч цацлага (OS PAVA) Олон хүнд нөлөөлөх бусад тусгай хэрэгслүүд
---------------------------	---	---	---

3.1 ХОРИГЛОХ ШААРДЛАГАТАЙ ХЭРЭГСЛҮҮД

3.1.1 ЦАХИЛГААН ГҮЙДЛЭЭР ЦОХИГЧ ЗЭВСЭГ, ХЭРЭГСЭЛ

**ХЭРЭГЛЭХИЙГ
ХОРИГЛОНО**

ЦАХИЛГААН ГҮЙДЛИЙН НӨЛӨӨГӨӨР ШҮҮД
ХҮЧТЭЙ ЦОЧРООХ ЗЭВСЭГ, ХЭРЭГСЭЛ

ЦАХИЛГААН ГҮЙДЛЭЭР ЦОХИГЧ БҮҮ, ЦАХИЛГААН БОРООХОЙ, ЦАХИЛГААН БАМБАЙ



Зураг (Зүүнээс баруун тийш) цахилгаан бороохой, цахилгаан гүйдлээр цохигч бүү, цахилгаан бамбай, цахилгаан гүйдэлтэй барих хэрэгсэл (бүх зураг зохиогчийн эрхээр баталгаажсан ©Robin Ballantyne/Omega Research Foundation)

Эдгээр цахилгаан гүйдлээр цохигч зэвсэг, хэрэгслийг зөвхөн гартаа барьж тодорхой этгээдийн эсрэг хэрэглэх бөгөөд биеийн тодорхой хэсэгт хүчтэй өвдөлтийг үзүүлэх хэдий ч чадамжид нөлөө үзүүлдэггүй. Дээрх хэрэгслийн өөрийн онцлог, дизайн, хэрэглээний онцлог зэргээс үүдэн учирч болох эрсдэлийг хүлээн зөвшөөрөх боломжгүй юм. Түүнчлэн тухайн хэрэгслийн тусгай товчлуур дээр дарснаар маш хүчтэй цахилгаан гүйдлээр цохих бөгөөд хүний биед тэсвэрлэшгүй их өвдөлтийг үзүүлдэг учир удаан хугацаанд, олон дахин давтан хэрэглэх нь эрүү шүүлтийн зориулалттай хэрэгсэл болгон хувиргадаг. НҮБ болон бүс нутгийн хэмжээнд эрүүдэн шүүх асуудлаар ажилладаг хөндлөнгийн шинжээчид, Эмнести Интернэшнл болон эрүүдэн шүүхийн эсрэг үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагууд дэлхийн өнцөг булан бүрт явагдаж байгаа хүчирхийллийг тохиолдлуудыг баримтжуулжээ.⁷



СЕРБИ УЛС: ХҮЧЭЭР ХЭРЭГ ХҮЛЭЭЛГЭХ ЗОРИЛГООР ЦАХИЛГААН ГҮЙДЛЭЭР ЭРҮҮДЭН ШҮҮЖЭЭ

Сербийн цагдаа нар хоригдлуудад хүчээр эрүүгийн хэрэг тулган хүлээн зөвшөөрүүлэх зорилгоор цахилгаан гүйдлээр эрүүдэн шүүж, хүнлэг бус, хэрцгий хандаж байсныг Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх асуудлаарх Европын Хороо баримтжуулжээ.⁸ 2017 оны 3 дугаар сард баривчлагдсан нэгэн хүнийг цагдаа нар Хотын Цагдаагийн Төв байранд аваачиж, улмаар хоёр гарыг нурууны хойно нь гавлан сандал дээр хүчээр суулган хэд хэдэн удаа биед нь цохиж, гартаа барьсан цахилгаан гүйдлээр цохигч хэрэгслээр (20 орчим см урт хэмжээтэй эрүүдэн шүүх хэрэгсэл) хавирга, хөл болон нурууны хойно нь олон удаа цахилгаанаар цохиулжээ.

7 Эмнести Интернэшнл, Итали дахь зөрчилдөөн, Европын Холбооны байр суурь дүрвэгсэд болон шилжин суурьшигчдын эрх зөрчигдөхөд хүргэж байгаа нь, (Индекс: EPR 30/5004/2016) хуудас 8, <https://www.amnesty.org/en/documents/epr30/5004/2016/en/>; Эмнести Интернэшнл, Филиппиний цагдаа нар хууль ёсыг үгүйсгэн эрүү шүүлт хэрэглэж байгаа нь, (Индекс ASA35/007/2014), хуудас 75, <https://www.amnesty.org/en/documents/asa35/007/2014/en/>; Эмнести Интернэшнл, Тайлан 2016/17 (Индекс: POL 10/4800/2017) хуудас 308, <https://www.amnesty.org/en/documents/pol10/4800/2017/en/>

8 Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх Европын Хороо (ЭШУСЕХ), 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс 6 дугаар сарын 7 хүртэл Серби улсад хийсэн айлчлалын талаарх тус улсын засгийн газарт хүргүүлсэн тайлан, CPT/inf (2018), Страсбург, 2018 оны 6 дугаар сар 21, дэлгэрэнгүйг дараах холбоосоор харна уу. <https://rm.coe.int/16808b5ee7>

Өөр нэг баривчлагдсан иргэнийг цагдаа нар Хотын Цагдаагийн Төв байранд аваачин гарыг нь нурууны ард нь гавлан, сум үл нэвтрэх хантааз өмсгөн хэд хэдэн талаас нь гараар болон бороохойгоор цохижээ. Цаашлаад бэлэг эрхтнийг нь цахилгаанаар цохиулсны улмаас хэдэн хоногийн турш цустай шээсэн хэмээн тухайн иргэн мэдүүлжээ.

Унгарын хил дээрээс баривчлагдсан бас нэгэн иргэнийг Нови Сад дүүргийн Цагдаагийн хэсэгт хүргэж байх үед цагдаа нар гартаа барьсан хэрэгслээр түүний гуяын дотор талын хэсэг болон төмсгийг олон удаагийн давтамжтайгаар цахилгаан гүйдлээр цохиулжээ. Тэгж эрүүдэн шүүснийхээ дараагаар түүнийг мөрдөн байцаагчийн өрөөнд гавлан авчирчээ.

ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОНО

ХҮНИЙ БИЕД БЭХЛЭН ЦАХИЛГААН ГҮЙДЛЭЭР ЦОЧРООХ ХЭРЭГСЛҮҮД

ЦАХИЛГААН ГҮЙДЛЭЭР ЦОХИГЧ БҮС, ХӨЛНИЙ ГАВ, БООЛТ



Зураг (Зүүн талаас баруун тийш) Цахилгаан гүйдлээр цохигч бүс, хөлний гав (үйлдвэрлэгч компанийн сурталчилгааны материалаас авч хэрэглэв), цахилгаан гүйдлээр цохигч боолт (Сүүлийн зургийг зохиогчийн эрхээр хамгаалагдсан. ©Robin Ballantyne/Omega Research Foundation)

Хоригдлын биед шууд бэхлэн, алсын удирдлагаар удирдах боломжтой олон төрлийн цахилгаан гүйдлээр цохигч хэрэгсэл байдаг. Үүнд: цахилгаан гүйдлээр цохигч бүс, хантааз, боолт зэргийг нэрлэж болно. Эдгээрийг хэдийд ч идэвхжүүлэн хэрэглэх боломжтой бөгөөд зарим тохиолдолд олон цагаар үргэлжлүүлэн хэрэглэх нь ч бий. Тухайлбал, цахилгаан гүйдлээр цохигч бүс нь хоригдлын бөөрний дэргэд байрлуулсан электродуудаар дамжин 50.000 вольтын хүчдэлээр цохих учир хүчтэй өвдөлтийн улмаас хүний биеийн булчин огцом зангирч хөдөлгөөн хийх ямар ч боломжгүй болгодог. Үүний улмаас булчингийн сулрал, шээсээ барьж чадахгүй болох, зүрхний хэм алдах, зүрх гэнэт зогсох, арьс улайх гэх зэрэг сөрөг үр дагавар хүний биед илэрнэ.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Хороо⁹, Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Европын Хороо¹⁰ цахилгаан гүйдлээр цохигч бүс хэрэглэхийг эрс буруутган, ийм төрлийн хэрэгслийг хэрэглэх, түүнчлэн Америк, Африк болон Азийн улс орнуудад үйлдвэрлэж байгаа бусад ижил төрлийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах явдлыг бүрэн зогсоохыг зөвлөж байна. Дээрх хэрэгслийг Өмнөд Африк¹¹ болон АНУ-ын зарим мужид¹² хоригдлуудыг хянах зорилгоор ашигласаар байна.

9 Эрүүдэн Шүүхийн Эсрэг Хорооны тайлан, UN DOC. A/55/44 (2000), 180 дахь догол

10 ЭШУСХ-ны 20 дахь удаагийн тайлан, CPT/inf (2010)28, 2010 оны 10 дугаар сарын 26, 74 дэх догол

11 Омега Судалгааны Сан/Аюулгүй байдлын сургалтын төв, "Compliance through pain: Өмнөд Африкийн шоронгууд дахь цахилгаанаар цохигч хэрэгслүүд", 2015 оны 6 дугаар сар

12 Дэлгэрэнгүйг, Омега Судалгааны сан, "АНУ-ын мужийн хорих газруудад хүний биед бэхлэх цахилгаан гүйдлээр цохигч хэрэглэж байгаа нь", <https://omegaresearchfoundation.org/case>

3.1.2 МЕХАНИК АРГААР ХӨДӨЛГӨӨН ХЯЗГААРЛАГЧ

**ХЭРЭГЛЭХИЙГ
ХОРИГЛОНО**

**ТҮЙЛЫН ХАРГИС БӨГӨӨД ӨВТГӨХ ЗОРИУЛАЛТТАЙ
ХЯЗГААРЛАГЧ ХЭРЭГСЛҮҮД**

**ЭРХИЙ ХУРУУНЫ ГАВ, ХӨЛНИЙ ТӨМӨР ДӨНГӨ, ХУРУУНЫ ДӨНГӨ, ХҮЗҮҮНИЙ ДӨНГӨ,
БУСАД ХҮНДРҮҮЛСЭН БОЛОН ҮЯН ХЯЗГААРЛАГЧ ХЭРЭГСЛҮҮД**



Зураг. (бүх зураг зохиогчийн эрхээр баталгаажсан. ©Robin Ballantyne/Omega Research Foundation)

Нелсон Манделагийн дүрэм ба хөдөлгөөн хязгаарлагч хэрэгсэл

НҮБ-аас баталсан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм” (Нелсон Манделагийн дүрэм)¹³-д хорих газарт хязгаарлах хэрэгслийг ашиглахад баримтлах зарчим, хэм хэмжээг тодорхойлсон. Уг дүрэмд заасан зарчмын дагуу “Хоригдол бүр эрүүдэн шүүх болон хүнлэг бус хэрцгий хандах, нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэх явдлаас ангид, хамгаалагдсан байна” (1 дүгээр зүйл) хэмээн заасан бөгөөд “хүний биеийг хүчтэй өвтгөх, хүнлэг бус, хэрцгий хандах зориулалттай аливаа гинж, төмөр болон бусад хязгаарлагч хэрэглэхийг бүрэн хориглоно”. (47 дугаар зүйлийн 1) гэжээ.

Мөн дүрмийн 47 дугаар зүйлийн 2-т зааснаар “бусад хязгаарлагч хэрэгсэл” гэдэгт хүний биед өвдөлт учруулахгүй хэрэгслүүд хамаарах бөгөөд эдгээрийг хоригдлуудыг шилжүүлэх, эсхүл тэднийг шүүх хурал болон захиргааны холбогдох байгууллагад хүргэх үед хэрэглэж болно. Түүнчлэн хоригдол өөрийгөө санаатайгаар бэртээж гэмтээх, бусад этгээд болон эд хөрөнгөнд хохирол учруулах эрсдэлтэй бөгөөд үүнийг өөр арга замаар шийдвэрлэх боломжгүй болсон тохиолдолд хорих ангийн удирдлагын шийдвэрээр дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхээр заажээ. Уг харилцааг дүрмийн 48 дугаар зүйлд нарийвчлан зохицуулахдаа: хязгаарлагч хэрэгслийг зөвхөн хяналтын ердийн бусад арга хэмжээг хэрэглэсэн хэдий ч үр дүнд хүрээгүй тохиолдолд зайлшгүй шаардлагатай үед хэрэглэх бөгөөд шалтгаан нөхцөл арилсны дараа тэр даруй зогсооно. Харин эмэгтэйчүүдийг хөдөлмөр эрхэлж байхад, түүнчлэн хүүхэд төрүүлж байхад болон хүүхэд төрүүлсний дараа хязгаарлах хэрэгсэл хэрэглэхийг хатуу хориглохоор зохицуулжээ. Түүнчлэн дүрмийн 49 дүгээр зүйлд “хорих ангийн удирдлага нь хязгаарлах хэрэгслийг зориулалтын дагуу ашиглах, тэдгээрийг залхаан шийтгэх зориулалтаар ашиглах явдлыг багасгах зорилгоор хяналтын арга хэрэгслийг сонгохдоо анхаарч, холбогдох сургалтыг зохион байгуулах үүрэгтэй” хэмээн заажээ.

Гэвч Нелсон Манделагийн дүрмээр хориглосныг эс харгалзан зарим компаниуд хүний хөдөлгөөнийг зүй бусаар хязгаарлах зориулалттай хүчтэй өвтгөх механик хэрэгслүүдийг үйлдвэрлэсээр байна. Тэдгээрийн зарим нь хоригдлын бие махбодод хүчтэй өвдөлт үзүүлэхээс гадна сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох хортой үр дагавартай юм. Тэдгээрт гарын эрхий хурууны гав, хөлний дөнгө, гарын хурууны дөнгө, хүзүүний дөнгө болон хорих газрын хана, шал болон таазанд бэхэлсэн хөдөлгөөн хязгаарлах бусад хэрэгсэл хамаарна. Жишээ нь: Нэгэн компани хүний нэг гарыг хананд бэхэлсэн

¹³ НҮБ-ын “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм” (Манделагийн дүрэм), НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2015 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн 70/75 тогтоолоор баталсан, хавсралт.

гаванд гавлаж хөдөлгөөн хязгаарлах хэрэгслийг үйлдвэрлэж түүнийгээ чулуун боолт хэлбэрээр суурин бэхэлнэ хэмээн сурталчилж байсныг Омега Судалгааны Сан баримтжуулжээ. Тус компаний өгсөн мэдээллээр дээрх хэрэгсэл нь хоригдлыг хананд бат найдвартай гавлаж түүнийг чөлөөтэй хөдлөх боломжийг хязгаарлах зориулалтай ажээ. Түүнчлэн уг компани 5 хоригдлыг нэгэн зэрэг хананд бугуйлдан гавлах хэрэгсэл үйлдвэрлэн түүнийгээ “хэсэг бүлгээр нь гавлах боломж, ... суурин бэхлэгээ” хэмээн сурталчилж байжээ. Хачирхалтай нь тухайн компани өөрсдийн үйлдвэрлэсэн дээрх хоёр төрлийн бүтээгдэхүүнээ Зүүн Европын улс орнуудын “Дотоод хэргийн яам болон Холбооны Хилийн Үйлчилгээний алба”-аар зөвшөөрөгдсөн хэмээн тайлбарлажээ.¹⁴

ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОНО

ГЯНДАН ОР, ТӨМӨР САРААЛЖ БҮХИЙ ХӨДӨЛГӨӨН ХЯЗГААРЛАГЧ ОР



Зураг. Зүүн талд гяндан ор (Энэ зураг зохиогчийн эрхээр хамгаалагдсан), баруун талд төмөр сараалж бүхий хөдөлгөөн хязгаарлагч ор (компаний сурталчилгааны зурагнаас авч хэрэглэв)

Дээрх тусгайлан тоноглогдсон ор нь хашиж бэхэлсэн дөрвөн булан болон тааз хэсгээс бүрдэнэ. Ерөнхий зохион байгуулалтын хувьд хашиж хязгаарласан ор гэхэд болно. Энэхүү орны дор хаяж нэг талыг метал болон бусад материалаар хийсэн босоо бэхлэгээ бүхий сараалж эсхүл тор хэлбэртэй сараалжаар тоногдсон байх бөгөөд зөвхөн гадна талаас онгойх боломжтой. НҮБ-ын Хүний Эрхийн Хороо болон холбогдох шинжээчид Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пактын хэрэгжилтийг хянах явцдаа сэтгэцийн эмнэлэг болон бусад байгууллагууд өвчтөнийг энэ мэт оронд хязгаарлаж байгаа нь хүнлэг бус, хэрцгий бөгөөд хүний нэр төрийг доромжлон харьцаж байгаа үйлдэл хэмээн үзэж хязгаарлагч орны хэрэглээг бүрэн халахыг уриалжээ.¹⁵ Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Европын Хорооноос 2017 онд холбогдох стандартыг шинэчлэн найруулахдаа “Насанд хүрэгчдэд зориулсан сэтгэцийн эмчилгээний газарт хориглох арга хэрэгсэл”-ийн асуудлыг тусгайлан авч үзэж дээрх төрлийн орыг ямар ч тохиолдолд хориглохоор тусгажээ.¹⁶ Зарим улсад, тухайлбал Бүгд Найрамдах Чех улсад Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Европын Хорооноос гаргасан хязгаарлагч ор хэрэглэхийг практикт бүрэн халах талаарх тайланг¹⁷ эс хүндэтгэн сэтгэцийн эмнэлгүүдэд төмөр сараалж бүхий хөдөлгөөн хязгаарлагч ор хэрэглэсээр байна.¹⁸

14 Компани болон бүтээгдэхүүний талаарх мэдээллийг дараах эх сурвалжаас дэлгэрүүлэн үзнэ үү: “Европын Холбооны улсуудад эрүүдэн шүүх хэрэгслийг үйлдвэрлэж, худалдааж, ашиглаж байгаа нь”, Омега Судалгааны Сан, 2018 оны 6 дугаар сар. <https://omegaresearchfoundation.org/sites/default/files/uploads/Publications/ORF%20>

15 Хүний Эрхийн Хорооны ажиглалтын дүгнэлт, Словак, UN Doc. CCPR/CO/78/SVK, 2003 оны 8 дугаар сарын 22, 13 дахь догол мөр; Хүний Эрхийн Хорооны ажиглалтын дүгнэлт, БН Чех улс, UN Doc. CCPR/C/CZE/CO/2, 2007 оны 8 дугаар сарын 9, 13 дахь догол мөр

16 Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Европын Хороо, Насанд хүрэгчдийн сэтгэцийн эмнэлэгт хэрэглэдэг хязгаарлагч хэрэгсэл, (шинэчилсэн хувилбар), CPT/Inf(2017)6, 2017 оны 3 дугаар сарын 21.

17 Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Европын Хороо, 2014 оны 4 дүгээр сарын 1-10-ны хооронд Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Европын Хорооноос хийсэн айлчлалын талаарх Чех улсад илгээсэн тайлан, CPT/Inf (2015) 18, 2015 оны 3 дугаар сарын 31.

18 Төмөр сараалж хэрэглэснээс үүдэн бий болох эрсдэлийг Добринигийн сэтгэцийн эмнэлэгт 2012 оны 1 дүгээр сард дээрх хязгаарлагч оронд нас барсан 51 настай эмэгтэйн тохиолдолтой холбон тайлбарлажээ. Хорооноос үзэж байгаагаар “өвтөнг сэтгэцийн эмнэлэгт ирсэн өдөр нь хөдөлгөөн хязгаарлагч төмөр оронд хэдэн цаг байлгасан бөгөөд тэрээр торыг эвдэж, гоцгоонд нь боомилгоджээ. Өвчтөний өрөөнд бүрэн ажиллагаатай хяналтын камер байсан ч энэ бүхэн болж өнгөрчээ”, Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Европын Хороо, (2015 оны 3 дугаар сарын 31), 170 дахь догол мөр.

ХӨДӨЛГӨӨН ХЯЗГААРЛАХ ЗОРИУЛАЛТ БҮХИЙ САНДАЛ, ОР БОЛОН ТАВЦАН

Зураг. Хүний гар болон хөлний хөдөлгөөнийг хязгаарлагч бүхий сандал (Зургийг зохиогчийн эрхээр хамгаалсан.
©Robin Ballantyne/Omega Research Foundation)

Эмнести Интернэшнл болон Омега Судалгааны Сан нь хүний гар болон хөлний хөдөлгөөнийг хязгаарлагч төмөр тоноглол бүхий байцаалтын сандал гэх зэрэг олон холбогч бүхий хязгаарлагч хэрэгслийн худалдаалж байгаа талаарх мэдээллийг баримтжуулжээ.¹⁹ Түүнчлэн Эмнести Интернэшнлийн баримтжуулснаар ялангуяа БНХАУ-д хоригдлуудыг эрүүдэн шүүх зорилгоор эдгээртэй ижил төрлийн хөдөлгөөн хязгаарлагч хэрэгслийг хэрэглэсээр байна.²⁰ Хүнлэг бус, хэрцгий хандахад зориулагдсан энэ мэт хэрэгслийн худалдаа, хэрэглээг бүрэн хориглох шаардлагатай.

**БНХАУ: ХӨДӨЛГӨӨН ХЯЗГААРЛАГЧ САНДАЛД ГАР,
ХӨЛӨӨ ДӨНГӨЛҮҮЛСЭН ХҮНИЙ ЭРХИЙН ХУУЛЬЧ**

Тус улсын хорих газар болон хууль сахиулагч нар хоригдлуудын хөдөлгөөнийг хязгаарлах зориулалттай хүнлэг бус, хэрцгий олон төрлийн арга хэрэгсэл ашиглаж байгааг Эмнести Интернэшнл баримтжуулжээ. Хоригдлуудын гар болон хөлийг дөнгөлөхийн зэрэгцээ хөдөлгөөн хязгаарлагч төмөр сандалд удаан хугацаагаар суулгадаг байна.²¹

2017 оны 11 дүгээр сарын 21-нд хүний эрхийн төлөө тэмцэгч, хуульч Жианг Тианён "төрийн эрх мэдлийг түлхэн унагаахыг завдсан" хэрэгт буруутган хоёр жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэгджээ. Стандартад нийцээгүй хорих ангийн муу нөхцлийн улмаас эрүүл мэнд нь илтэд доройтсон бөгөөд түүний гар, хөлний хөдөлгөөнийг хязгаарласан төмөр тоноглол бүхий хөдөлгөөн хязгаарлагч сандал дээр суулгасан байсныг Жианг Тианёнгийн аав мэдээлжээ. Түүнчлэн түүнд өдөрт хоёр удаа үл мэдэх эм хүчээр уулгадаг бөгөөд түүний улмаас түүний ой ухаан эрс доройтож, муудсан хэмээн тэрээр ар гэрийнхэндээ хэлжээ.²²

19 Эмнести Интернэшнл болон Омега Судалгааны Сан, "Хүчин чармайлт: Цаазаар авах ял болон эрүүдэн шүүхэд ашиглах хэрэгслийн Европын улс орнууд дахь худалдааг эцэс болгох нь" (Индекс: АСТ 01/1632/2015); Хятад дахь Эрүүдэн шүүх болон залхаан шийтгэх хэрэгслийн худалдаа (Индекс: ASA 17/042/2014).

20 Эмнести Интернэшнл, Хөл, гар нь төмөр сандалд гавлагдсан хуульч, яаралтай арга хэмжээ, (Индекс: ASA 17/8818/2018); Эмнести Интернэшнл, Хүний эрхийг зөрчсөөр: Хятад дань эрүү шүүлт болон хэрэг хүчээр хүлээлгэлт, (Индекс: ASA 17/2730/2015).

21 Эмнести Интернэшнл, Хүний эрхийг зөрчсөөр: Хятад дань эрүү шүүлт болон хэрэг хүчээр хүлээлгэлт, (Индекс: ASA 17/2730/2015). <https://www.amnesty.org/download/Documents/ASA1727302015ENGLISH.PDF>

22 Эмнести Интернэшнл, Хөл, гар нь төмөр сандалд гавлагдсан хуульч, яаралтай арга хэмжээ, (Индекс: ASA 17/8818/2018);

3.1.3 КИНЕТИК НӨЛӨӨЛӨЛ БҮХИЙ ЗЭВСЭГ, ХЭРЭГСЭЛ

**ХЭРЭГЛЭХИЙГ
ХОРИГЛОНО**

ХҮНЛЭГ БУС, ХЭРЦГИЙ БӨГӨӨД АЮУЛТАЙ
КИНЕТИК НӨЛӨӨЛӨЛ БҮХИЙ ЗЭВСЭГ, ХЭРЭГСЭЛ

ӨРГӨСТ БОРООХОЙ, ӨРГӨСТ БАМБАЙ, ӨРГӨСТ ХАМГААЛАЛТ БҮХИЙ ӨМСГӨЛ,
ХҮНДРҮҮЛСЭН БОРООХОЙ БОЛОН БЭЭЛИЙ



Зураг. (зүүн талаас эхлэн) Өргөст бороохой, (дунд хэсэгт) өргөст бамбай, (баруун талд) Өргөст хамгаалалт бүхий өмсгөл (бүх зураг зохиогчийн эрхээр хамгаалагдсан. ©Robin Ballantyne/Omega Research Foundation)

Хүний биед маш хүнд гэмтэл учруулах боломжтой, туйлын хэрцгий гэгдэж болохуйц кинетик нөлөөлөл бүхий зэвсэг, хэрэгслийг цагдаа болон аюулгүй байдлыг хангах байгууллагуудад бэлтгэн нийлүүлж, худалдан борлуулдаг худалдааны сувгийг Эмнести Интернэшнл болон Омега Судалгааны Сан олж тогтоожээ. Худалдан борлуулж буй дээрх хэрэгсэлд хүний бие махбодод гэмтэл учруулах эрсдэлийг бууруулсан зүйл огт байхгүй, харин ч, хүний арьсыг урах, шалбалах, хурц үзүүр бүхий өргсөөр хатгах гэх зэргээр хүний биед хүнд гэмт учруулах зориулалтаар бүтээгджээ. Нэгэнт хүнийг өвтгөх, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох, хүнд гэмтэл учруулах зориулалттай учир дээрх хэрэгслийг хууль сахиулах үйл ажиллагаанд хуулийн дагуу хэрэглэх ямар ч боломжгүй билээ.

ОН.МН
СУДАЛГААНЫ САН

3.2 ХЯНАЛТТАЙГААР ХЭРЭГЛЭВЭЛ ЗОХИХ ХЭРЭГСЛҮҮД

3.2.1 ЦАХИЛГААН ГҮЙДЛЭЭР ЦОХИГЧ ЗЭВСГҮҮД



ЦАХИЛГААН ГҮЙДЛЭЭР ЦОХИГЧ ЗЭВСГҮҮД



Зураг. Цахилгаан гүйдлээр цохигч (энэ зураг зохиогчийн эрхээр хамгаалагдсан. ©Robin Ballantyne/Omega Research Foundation)


Цахилгаан гүйдлээр цохигч бууны галын сумнууд нь бууны эх биетэй цахилгаан гүйдэл дамжуулагч утсуудаар холбогдсон байх бөгөөд хэдэн метрийн зайнаас чиглүүлэн буудаж хэрэглэх боломжтой. Уг бууны сумнууд нь хүний биед наалдсан даруйд хүчтэй цахилгаан гүйдлээр цохиж улмаар хүний булчингийн үйл ажиллагааг бүрэн дарангуйлдаг. Дээрх нэг бүрийн тусгай хэрэгслийг хүний амь нас болон биед хүнд гэмтэл учруулахаас зайлсхийх зорилгоор зөвхөн галт зэвсэг хэрэглэхээс өөр сонголт байхгүй болсон нөхцөлд хэрэглэнэ. Цагдаа нар хүнийг олон удаагийн давтамжтайгаар цахилгаан гүйдлээр цохих, удаан хугацаанд үргэлжүүлэн хэрэглэх, нэмэлт өөр цахилгаан гүйдлээр цохигч хэрэгслүүдтэй давхардуулан хэрэглэх зэргийг холбогдох дүрэм, журмын дагуу хатуу хориглодог. Түүнчлэн гавлаж, дөнгөлөх зэргээр хөдөлгөөнийг нь хязгаарласан хүн, хүүхэд, өндөр настан, жирэмсэн эмэгтэй зэрэг хүмүүст энэ хэрэгслийг ашиглахыг хориглоно.

Хүний биед чиглүүлэн буудах шаардлагагүй зарим өөр төрлийн цахилгаан цохигч хэрэгслүүд байдаг. Эдгээр нь өөртөө цахилгаан гүйдэл дамжуулагчтай бөгөөд хүний биед хүргэж цахилгаанаар шууд цохих боломжтой, алсаас хэрэглэх боломжгүй. Энэ нь хүний биед хүчтэй өвдөлт үзүүлэх хэдий ч булчингийн хөдөлгөөнийг бүрэн дарангуйлж хяналтгүй болгохгүй. Эрүү шүүлт, болон бусад байдлаар хүнлэг бус, хэрцгий хандаж шийтгэх зорилгоор ашиглах боломжтой учир дээрх төрлийн хэрэгслийг хууль сахиулах үйл ажиллагаанд хэрэглэхийг хориглох шаардлагатай.

3.2.2 МЕХАНИК ХЯЗГААРЛАГЧ ХЭРЭГСЛҮҮД



ГАР БОЛОН ХӨЛНИЙ ГАВ



Зураг. Зүүн талд гарын гав, баруун талд хөлний гав (дээрх зурагнууд зохиогчийн эрхээр хамгаалагдсан).
©Robin Ballantyne/Omega Research Foundation)

Хууль сахиулах үйл ажиллагаанд түгээмэл ашигладаг эдгээр механик хязгаарлагчийг хөдөлгөөн хязгаарлах зорилгоор хүний биед холбож хэрэглэдэг. Олон улсын хүний эрхийн зохицуулалт, хэм хэмжээнд нийцүүлэн хэрэглэж байгаа тохиолдолд гар болон хөлний гавыг хоригдлын хөдөлгөөнийг хязгаарлах, аюулгүй байдлыг хангах хууль ёсны зорилгоор ашиглах боломжтой.

Дээрх хэрэгслийг хэрэглэх үндэслэл, журам, хязгаарлалт нь зөвхөн Нелсон Манделагийн дүрэм төдийгүй олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн байх шаардлагатай. Гэвч хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд түгээмэл хэрэглэдэг эдгээр хязгаарлагч хэрэгслийг хүний биед мэдрүүлэх өвдөлт, зовиурыг нэмэгдүүлэх зорилгоор хэт чангалах, ямар нэгэн суурин зүйлд бэхлэх, хэт удаан хугацаагаар хэрэглэх, өлгөх, дүүжлэх болон элдэв аргаар дэглэх, эсхүл бусад нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, жишээ нь бороохой, нулимс асгаруулагч, чинжүүтэй цацлага зэрэгтэй хавсруулан хэрэглэж байгааг НҮБ, бүс нутгийн хүний эрхийн болон терроризмтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд баримтжуулжээ.

Дээрх нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэх үндэслэл, журам, хязгаарлалт нь зөвхөн Нелсон Манделагийн дүрэм төдийгүй олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн бусад хэм хэмжээнд нийцсэн байх шаардлагатай.

ХӨДӨЛГӨӨН ХЯЗГААРЛАГЧ САНДАЛ, ОР, ТАВЦАН

Зураг Зүүн талд хөдөлгөөн хязгаарлагч сандал, баруун талд хүлж хөдөлгөөн хязгаарлах ор (Дээрх зургууд зохиогчийн эрхээр хамгаалагдсан. ©Robin Ballantyne/Omega Research Foundation)

Хүний биеийн бараг бүх хэсгийн хөдөлгөөнийг хязгаарлах хэрэгслийг өндөр хяналттай эмнэлгийн нөхцөлд яаралтай тусламж үзүүлэх үед, эсхүл хүнийг амиа хорлохоос урьдчилан сэргийлэх зэрэг зорилгоор хэрэглэж болно. Харин хууль сахиулах үйл ажиллагаа болон ял, шийтгэлийн зорилгоор хүний биеийн хөдөлгөөнийг хязгаарлагч олон холбогч хэрэгслийг (ор, сандал гэх мэт) зарим компаниуд худалдан борлуулж²³ байгааг Эрүүдэн шүүхийн эсрэг НҮБ-ын Хороо буруутган, практикт хэрэглэх явдлыг бүр мөсөн зогсоохыг шаарджээ. Учир нь “цагдан хорих байранд хөдөлгөөн хязгаарлагч сандал хэрэглэх” нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүнийг нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенцийн 16 дугаар зүйлд заасан зохицуулалтыг ноцтой зөрчиж байгаа юм.²⁴

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

23 Эмнести Интернэшнл болон Омега Судалгааны Сан, “Хүчин чармайлт: Цаазаар авах ял болон эрүү шүүлтэд ашиглах хэрэгслийн Европын улс орнууд дахь худалдааг эцэс болгох нь” (Индекс: АСТ 01/1632/2015); Хятад дахь Эрүүдэн шүүх болон залхаан шийтгэх хэрэгслийн худалдаа (Индекс: ASA 17/042/2014).

24 Эрүүдэн шүүхийн эсрэг Хорооны дүгнэлт, зөвлөмж: АНУ, UN Doc. CAT/C/24/6, 2000 оны 5 дугаар сарын 15, .6(с) догол



ШИНЭ ЗЕЛАНД: ХҮЛЭГЧ ОР БОЛОН ЦЭЭЖНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙГ ХЯЗГААРЛАГЧ САНДАЛ

Шинэ Зеландын Омбудсмен²⁵ болон тус улсын Хүний Эрхийн Комиссоос тусгайлан томилогдсон хараат бус шинжээч Шарон Шалев²⁶ нарын гаргасан тайлангуудад тухайн улсын цагдан хорих газарт сэжигтнүүдийг ялангуяа уугуул иргэд болох Маори иргэдийг удаан хугацаагаар хорих, хязгаарлах хэрэгслийг хэрэглэх явдал газар авсан байдлыг онцлон тэмдэглэжээ. Хүлэгч ор болон цээжний хөдөлгөөнийг хязгаарлагч сандал зэргийг урьдчилан хорих газарт хэрэглэж байгааг тайланд онцгойлон дурдаад энэхүү арга нь бусад арга хэрэгслийг ашигласны дараа эцэслэн хэрэглэдэг арга эсэх нь тодорхойгүй байна хэмээн дүгнэжээ.

Хүлэгч ор гэдэг нь хоригдлууд өөрийн биед гэмтэл учруулахаас сэргийлж тэдний цээж болон гар, хөл зэргийг хөдөлгөөнгүй барих зорилгоор хэрэглэдэг олон зориулалттай холбогч хэрэгсэл бөгөөд уг хэрэгслийг эмнэлгийн байгууллагын албан ёсны зөвшөөрөлтэйгөөр, шатлалын хамгийн сүүлийн арга болгон хэрэглэхээр тус улсын хуульд заажээ. Хүний эрхийн омбудсмен өөрийн тайландаа хязгаарлах хэрэгслийг эрүүдэн шүүх, болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хандаж, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэж байгаа тохиолдлуудыг нарийвчлан авч үзжээ. Хөрөнгө, санхүүгийн хомсдол, болон хоригдлуудад зориулсан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хангалтгүй байдал нь хязгаарлах хэрэгслийг практикт түгээмэл хэрэглэхэд хүргэж байна хэмээн дүгнэжээ. Нэгэн хоригдлыг хүлэгч оронд 600 орчим цаг хүлж хөдөлгөөнийг нь хязгаарласан бол, өөр нэг хоригдлыг 3 сарын хугацаанд гарыг нурууны ард нь гавлаж хөдөлгөөн хязгаарлагч сандалд өдөрт дунджаар 21 цаг суулгадаг байсанг тайланд дурджээ.²⁷

Хүлэгч ор болон цээжний хөдөлгөөнийг хязгаарлагч сандал зэргийг урьдчилан хорих газарт хэрэглэж байгааг тайланд онцгойлон дурдаад энэхүү арга нь бусад хууль ёсны арга хэрэгслийг ашигласны дараа эцэслэн хэрэглэдэг арга эсэх нь тодорхойгүй байна хэмээн дүгнэжээ.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

25 Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцийн Нэмэлт Протоколын дагуу хийсэн Омбудсмений дүгнэлт 2017: Хязгаарлах хэрэгслээс үүдэлтэй асуудлууд, 2017 оны 3 дугаар сарын 1, <http://www.ombudsman.parliament.nz/resources-and-publications/documents/a-question-of-restraint>

26 Доктор Шарон Шалев, “Хэвшмэл үзлээс татгалзах уу? Шинэ Зеландад тусгаарлах болон хязгаарлах хэрэгсэл ашиглаж байгаа нь талаарх ерөнхий мэдээлэл” <http://www.seclusionandrestriction.co.nz/>

27 Омбудсмений тайлан, “Хязгаарлах хэрэгслээс үүдэлтэй асуудлууд”, 24 дэх нүүрт хэд хэдэн тодорхой тохиолдлуудыг нарийвчлан авч үзжээ. Эрүүдэн шүүгдсэн 5 хоригдлын тохиолдол дээр үндэслэн хоригдлуудад хүлэгч ор олон цээжний хөдөлгөөн хязгаарлагч хэрэглэх нь Эрүүдэн шүүх, болон бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн 16 дугаар заалтыг зөрчсөн хэмээн дүгнэжээ.

3.2.3 КИНЕТИК НӨЛӨӨЛӨЛ БҮХИЙ ЗЭВСЭГ, ХЭРЭГСЭЛ

**ХЯНАЛТ
ШААРДЛАГАТАЙ**

КИНЕТИК НӨЛӨӨЛӨЛ БҮХИЙ ЗЭВСЭГ ХЭРЭГСЭЛ

БОРООХОЙ, ХУВАНЦАР БОЛОН РЕЗИН СУМ



Дээрх зургууд зохиогчийн эрхээр хамгаалагдсан.
©Robin Ballantyne/Omega Research Foundation)

Эмнести Интернэшнл болон Омега Судалгааны Сан нь гартаа барих зориулалт бүхий кинетикийн нөлөөлөл бүхий нэг бүрийн тусгай хэрэгсэл (бороохой гэх мэт), түүнчлэн буудах зориулалттай хуванцар болон резин сум үйлдвэрлэж, борлуулж байгаа компаниудыг дэлхийн бүхий л бүс нутагт олж тогтоожээ.²⁸ Гарт барих болон буудах зориулалт бүхий дээрх хэрэгслийг хууль сахиулагчид нийгмийн хэв журмыг хамгаалах болон цагдан хорих байранд дэг журам сахиулах зорилгоор практикт өргөн хэрэглэдэг. Олон улсын хүний эрхийн зохицуулалт, хэм хэмжээнд нийцүүлэн дээрх хэрэгслийг хууль сахиулах зорилгоор хуулийн дагуу хэрэглэж болно.²⁹ Гэхдээ кинетикийн энергид суурилсан дээрх хэрэгслүүдийг хүний

арьсыг урах, шалбалах, сүлбэх зэргээр хүнд гэмтэл учруулах зориулалттайгаар бүтээж, үйлдвэрлэж болохгүй. Ердийн зориулалттай байсан ч хүний биед хүнд гэмтэл учруулах эрсдэлтэй байдгийг анхаарах хэрэгтэй. Түүнчлэн хууль сахиулагчид гарцаагүй шаардлага үүсээгүй байхад хүч, албадлагыг хэтрүүлсэн хэрэглэж хүнийг эрүүдэн шүүсэн, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар харьцсан, улмаар хүнд гэмтэл учруулах, хүний амь насыг хөнөөсөн гэх зэрэг үйл баримтуудыг хүний эрхийн байгууллагууд тогтмол баримтжуулсаар байна.³⁰



УКРАИН: БОРООХОЙ ХЭРЭГЛЭСЭН НЬ

Украины цагдаа нар 2013 оны 11 дүгээр сарын 21-ны өдрөөс эхлэн 2014 оны 2 дугаар сарын 22-ны өдөр хүртэл тус улсад өрнөсөн Евромайданы эсэргүүцлийн жагсаалын үеэр жагсагчдын эсрэг бороохой хэрэглэжээ. Эхэндээ жагсаал тайван замаар эхэлсэн хэдий ч аажимдаа жагсагчид болон хууль сахиулагчдын хоорондын зөрчилдөөнт харилцаа улам даамжирч эцэстээ цуст мөргөлдөөн болон хувирчээ. Цагдаа нарын хүчирхийлэл нь Евромайданы эсэргүүцлийг улам бүр өдөөж хүчирхийлэл улам газар авахад хүргэжээ.

2013 оны 12 дугаар сарын 01-ний өдөр болсон тайван жагсаалын үеэр Киев хот дахь Ерөнхийлөгчийн ордны ойролцоо Банкова гудамжинд зугтааж байгаа жагсагчдыг цохиж, зодож байгаа цагдаагийн үйлдлийн эсэргүүсэн хэсэг бүлэг жагсагчид хууль зөрчсөн үйлдэл хийжээ.

28 Жишээ болгон Эмнести Интернэшнл болон Омега Судалгааны Сан, "Хятад дахь Эрүүдэн шүүх болон залхаан шийтгэх хэрэгслийн худалдаа"; (Индекс: ASA 17/042/2014). "Хүчин чармайлт: Цаазаар авах ял болон эрүү шүүлтэд ашиглах хэрэгслийн Европын улс орнууд дахь худалдааг эцэс болгох нь" (Индекс: АСТ 01/1632/2015); Омега Судалгааны Сан, "Европын улс орнууд дахь эрүү шүүлтийн хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа, ашиглалт", 208 оны 6 дугаар сар, Омега Судалгааны Сан, "Өмнөд Америк дахь эрүү шүүлт болон хэрэг хүлээлгэх хэрэгслүүд: Ашиглалт, үйлдвэрлэл болон худалдаа" 2016 оны 7 дугаар сар.

29 Кинетик нөлөөлөл бүхий хэрэгслийн хүний эрхэд нөлөөлөх байдлын талаар мэдэхийг хүсвэл, Эмнести Интернэшнл болон Омега судалгааны сангийн эрхлэн гаргасан "амь насанд аюулгүй болон хууль сахиулах үйл ажиллагаанд хэрэглэх бусад хэрэгслийн хүний эрхэд үзүүлэх нөлөөлөл" гарын авлагыг уншина уу, (Индекс: АСТ 30/1305/2015).

30 Илүү их жишээ баримтыг мэдэхийг хүсвэл, Омега Судалгааны Сан, "Европын улс орнууд дахь эрүү шүүлтийн хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа, ашиглалт", 2018 оны 8 дугаар сар

Жагсаалын үеэр олон хүний амь нас эрстэж, хамгийн багадаа 1000 орчим хүн хүндээр гэмтсэн ...

Беркутын цагдаа нар цугтааж байгаад газарт унасан иргэдийг бороохойгоор цохих, өшиглөх зэргээр хүч хэрэглэхийн зэрэгцээ баригдсан, саатуулагдсан, ямар нэгэн эсэргүүцэл үзүүлээгүй жирийн иргэдийг үргэлжлүүлэн цохиж зодсоор байлаа. Тэдгээрийн дунд 32 настай Олександр Останшенко байсан бөгөөд түүнийг цагдаа нар өвдөг сөгдүүлэн бороохойгоор удаа дараа цохижээ.³¹ Тэрээр хэсэг бүлэг хүмүүсийн хамт баривчлагдан, нийтийн эмх замбараагүй байдлыг зохион байгуулсан хэргээр шийтгэгджээ. Тун удалгүй тэдгээр иргэдэд холбогдох эрүүгийн хэргийг дахин авч хэлэлцэн хэрэгсэхгүй болгожээ. Гэхдээ нэгэн иргэний биед учирсан гэмтлийг харгалзан эмнэлэгт хэвтүүлжээ.

Өөр нэгэн хохирогч бол 51 настай Ирина Рабченко юм. Уг эмэгтэйд Институшка гудамжны ойролцоохноос жагсаалыг хөндлөнгөөс хараад зогсож байхад нь Беркутын нэгэн цагдаа нүүр лүү нь бороохойгоор цохисны улмаас нэг нүд нь сохорч, гавлын яс нь цуурчээ.

Жагсаалын үеэр олон хүний амь нас эрстэж, хамгийн багадаа 1000 орчим хүн хүндээр гэмтсэн бөгөөд Евромайданы жагсаалын дараа Украин эрх баригчид жагсаалын үеэр хохирсон иргэдийн асуудлыг шударгаар шийдвэрлэж, хүний эрхийн зөрчил үйлдсэн зохих этгээдүүдэд хариуцлага хүлээлгэхээр амласан хэдий ч дээрх амлалт бодит байдалд хэрэгжээгүй байна.³² Дээрх хүний эрхийн зөрчилтэй холбогдуулан Беркутын цагдаагийн албан хаагчидтай холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа ч сэжигтнүүдийг тодорхойлох боломжгүй үндэслэлээр эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлээгүй байна.



ВЕНЕСУЭЛ: РЕЗИН СУМАНД ӨРТӨЖ ХАРААГҮЙ БОЛСОН НЬ

Намайг тагтан дээрээ гартал нэг цагдаа намайг хараад буугаа онилон тэр даруй буудсан.

Жон Майкл Ортиз Фернанес

2014 оны 2 дугаар сараас эхлэн 7 дугаар сар хүртэл Венесуэл улсад өрнөсөн засгийн газрын эсрэг олон нийтийн жагсаалын үеэр хууль сахиулагчид иргэдийн эсрэг хүч, албадлагыг хэтрүүлэн хэрэглэсэн талаарх олон тохиолдлыг Эмнести Интернэшнл баримтжуулсан. Цагдаагийн албан хаагчид ямар нэгэн зэвсэг, хэрэгсэлгүй болох нь илэрхий байгаа жирийн иргэдийн эсрэг, ямар нэг анхааруулга санамж өгөхгүйгээр тэднийг санаатайгаар гэмтээх зорилгоор резин сумтай буугаар бууждээ. 2014 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр 16 настай Жон Майкл Ортиз Фернанес хүү Сан Кристобал дахь (Тачира хот) гэрийнхээ тагтан дээр гартал нэгэн цагдаа резин сумтай буугаар буудаж зүүн талын нүдийг нь маш хүнд гэмтээжээ. Резин сум түүний нүдний торлог бүрхэвчийг бэртээсэн байна.³³

31 Дүрс бичлэгийг дараах холбоосоор үзнэ үү. <https://www.youtube.com/watch?v=fIMFIA55SBg>

32 Эмнести Интернэшнл, Украин: Евромайданы дараах он жилүүд, шударга ёс үнэгүйтэй байгаа нь, (Индекс: EUR 50/001/2015), <https://www.amnesty.org/download/Documents/EUR5000012015ENGLISH.pdf>

33 Эмнести Интернэшнл, Тайлан 2014/15 – Венесуэлийн секц, POL 10/001/2015, <https://www.amnesty.org/en/latest/research/2015/02/annual-report-201415/>

3.2.4 ОЛОН ХҮНД НӨЛӨӨЛӨХ ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ

**ХЯНАЛТ
ШААРДЛАГАТАЙ**

ОЛОН ХҮНД НӨЛӨӨЛӨХ ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ

НУЛИМС АСГАРУУЛАГЧ ХИЙ, ЧИНЖҮҮН ЦАЦЛАГА



Зураг. Нулимс асгаруулагч хий буудагч болон нулимс асгаруулагч хийгээр буудагч Дрон (дээрх зургийг зохиогчийн эрхээр хамгаалсан. ©Robin Ballantyne/Omega Research Foundation)

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэлд химийн хорт бодис агуулсан нулимс асгаруулагч хий, чинжүүт цацлага, амьсгал боогдуулагч хий зэрэг цугларсан олон хүнийг тараах зориулалттай хэрэгслүүд хамаардаг (гараар шидэгч болон тусгай буу зэвсгээр буудах зориулалт бүхий тэсрэх бөмбөг, усан хөөрөг буюу даралтад усаар буудагч гэх мэт). Тэдгээрийн зарим нь (нулимс асгаруулагч) нэг, эсхүл цөөн тооны хүнд хэрэглэх зориулалттай байх нь ч бий. Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хүний эрхийн хэм хэмжээ болон уг хэрэгслийг үйлдвэрлэгч байгууллагаас өгсөн зааврыг зөрчиж хэрэглэвэл маш хортой үр дагавар учруулдаг. Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэтрүүлсэн хэрэглэх, түүнчлэн хүмүүс зугтах боломжгүй хязгаарлагдсан орчинд химийн хорт бодис бүхий хэрэгслийг ашиглах нь хүний биед хүнд хор хөнөөл учруулах, тэр ч бүү хэл үхэлд хүргэх эрсдэлтэй. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан, эмэгтэйчүүд болон хүүхдүүд хамгийн эрсдэлтэй бүлэгт хамаарна.

Хууль сахиулах байгууллагын хэрэглэж байгаа олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийн ихэнх нь ойрын зайд тохируулан хэрэглэх зориулалттай байдаг (нулимс асгаруулагч гранат, буу, болон чинжүүт цацлага, нулимс асгаруулагч хөөргөгч). Гэвч дээрх хэрэгслийг хэрэглэхдээ хэн нэгэн этгээд рүү чиглүүлэн онилон хэрэглэсэн, хорих газар болон цагдан хорих газарт хүнийг эрүүдэн шүүх, болон бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий хандах зориулалтаар ашигласан зэрэг олон тохиолдол бүртгэгджээ. Газийн зурвас, Венесуэл³⁴, Конгогийн Бүгд Найрамдах Ардчилсан улс зэрэг улсад олон хүнийг гэмтээх замаар хуран цугларсан хүнийг тараах зорилгоор дээрх тусгай хэрэгслийг хэт их хэмжээгээр хэрэглэж байгааг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

Омега Судалгааны Сан олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг холын зайнаас хэрэглэж тусгалын хамрах хүрээг өргөжүүлэн хөгжүүлж байгаа үйлдвэрлэлийн олон төрлийн ажиллагааг баримтжуулжээ. Үүний үр дүнд мэдээж хүний биед учруулах эрсдэлийн хамрах хүрээ нэмэгдэх

34 2017 онд, Венесуэлийн аюулгүй байдлын хүчин болон засгийн газрын санхүүжүүлсэн зэвсэгт бүлэглэлүүд нь жагсаал, цуглаан болон бусад эсэргүүцлийн ажиллагаанд иргэдийг оролцуулахгүй хэмээн айлгах зорилгоор хэд хэдэн айлын орон байр руу хүч түрэмгийлэн орж шөнийн түрэмгийллийн ажиллагаа явуулжээ. Албаныхан айлуудын гэр рүү нулимс асгаруулагч хий, хийн буу зэрэг олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслээр бууджээ. Хүмүүс амьсгалахад ихээхэн хүндрэлтэй болсны зэрэгцээ зарим хүн нулимс асгаруулагч хийнд хордож, буудуулсаны улмаас эмнэлэгт хүргэгджээ. Дэлгэрэнгүй мэдээллийг дараах эх сурвалжаас олж авна уу. Эмнести Интернэшнл, Шөнөөр түрэмгийлэх ажиллагаа: Иргэдийн орон байр руу хүч хэрэглэн хууль бусаар нэвтэрсэн нь, (Индекс: AMR 53/7285/2017), <https://www.amnesty.org/download/Documents/AMR5372852017ENGLISH.PDF>

юм. Үүнд өргөн талбайг хамран цацах зориулалт бүхий нулимс асгаруулагч цацлага, автомат гранат хөөргөгч, нэгэн зэрэг олон тооны нулимс асгаруулагч харвагч төхөөрөмж, өргөн тусгалын калибрын пуужин хөөргөгч зэргийг нэрлэж болно.³⁵ Олон хүнд нөлөөлөх цацлага болон хөөргөгч пуужин бүхий хэрэгслийг алсын удирдлага ашиглан газарт болон агаарт хэрэглэх явдлыг хөгжүүлэх нь орчин үеийн чиг хандлага болж байна. Эдгээр төхөөрөмжийг ямар тохиолдолд, хэрхэн хэрэглэх эсэх, энэ нь олон улсын эрх зүйн зохицуулалт, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэх нь шийдвэрлэвэл зохих маргааныг үүсгэж байна. Ази болон Европын зарим улсад үйлдвэрлэж, хөгжүүлж байгаа олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийн өргөн тусгалын техник төхөөрөмжүүд болох пуужин, пуужин харвагч болон их буу зэрэг нь хууль сахиулах үйл ажиллагаанд ашиглах нь зохимжгүй хэрэгслүүд юм.



БҮГД НАЙРАМДАХ АРДЧИЛСАН КОНГО УЛС: ТАЙВАН ЗАМААР ЖАГСАГЧДЫН ЭСРЭГ НУЛИМС АСГАРУУЛАГЧ ХИЙ БОЛОН ГАЛТ ЗЭВСЭГ АШИГЛАСАН НЬ

2017 оны 2 дугаар сараас 2018 оны 12 дугаар сарын хооронд Католик сүмийн бүлгийн гишүүн болох Лэй Координэшнийн Хороо нь 2016 оны 12 сарын 31-ний өдөр байгуулагдсан иргэдэд нээлттэй, аюулгүй хамгаалалтын байраар хангах талаарх хэлэлцээрийн³⁶ хэрэгжилтийг шаардаж сар бүрийн нэг өдөр тайван жагсаал зохион байгуулдаг байв. Жагсагчид 2017 оны 12 дугаар сарын 31, 2018 оны 1 дүгээр сарын 21 болон 2 дугаар сарын 25-ний өдрүүдэд хэд хэдэн газарт жагсаал зохион байгуулсан боловч хууль сахиулагчдын харгис бөгөөд системтэйгээр хэрэглэсэн хүчирхийлэлтэй нүүр тулжээ. Ихэнх тохиолдолд, цагдаа, тусгай хамгаалагч нар жагсагчидтай ямар нэгэн яриа, хэлэлцээр, зөвшилцөл хийхгүйгээр хүч албадлага хэрэглэж, тэр бүү хэл иргэдийн сүмд нэвтрэх орох эрхийг хязгаарлаж, зэвсэггүй энгийн номхон иргэдийн эсрэг нулимс асгаруулагч хий ашиглажээ. Жагсаалын үеэр 15 жагсагч нас барж, олон хүн хүндээр шархдаж, баривчлагджээ.³⁷



Ерөнхийлөгч Жозеф Кабилагийн засаглалыг эсэргүүцэн Католикийн сүмээс зохион байгуулсан жагсаал үеэр цагдаагийн тусгай хүчнийхэн Католик сүмийн санваартан болон жагсагчдын эсрэг нулимс асгаруулагч ажиглаж байгаа нь. Киншаса хот, Бүгд Найрамдах Ардчилсан Конго улс, 2018 оны 1 дүгээр сарын 21. (Энэ зураг зохиогчийн эрхээр баталгаажсан. © REUTERS/Kenny Katombe)

- 35 Кровлей.М, Хил хязгаарыг тогтоох нь: Химийн зэвсгийг хориглох тухайн конвенцийн дагуу өргөн хүрээг хамарсан олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийн хэрэглэх арга ажиллагаа, Братфордын их сургууль/Омега Судалгааны Сан, 2013 оны 4 дүгээр сар, <http://www.css.ethz.ch/en/services/digital-library/>; Кровлей.М, Алсын удирдлага ашиглах нулимс асгаруулагчаар буудсан нь: Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг алсын удирдлага ашиглах хэрэглэх ажиллагаанд гарч буй өөрчлөл, шинэчлэл, Братфордын их сургууль/Омега Судалгааны Сан/Алсын Удирдлагын Төсөл, 2015 оны 12 дугаар сар, <https://omegaresearchfoundation.org/sites/default/files/uploads/Publications/Tear%20Gassing%20By%20>
- 36 Кровлей.М, Хил хязгаарыг тогтоох нь: Химийн зэвсгийг хориглох тухайн конвенцийн дагуу өргөн хүрээг хамарсан олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийн хэрэглэх арга ажиллагаа, Братфордын их сургууль/Омега Судалгааны Сан, 2013 оны 4 дүгээр сар, <http://www.css.ethz.ch/en/services/digital-library/>; Кровлей.М, Алсын удирдлага ашиглах нулимс асгаруулагчаар буудсан нь: Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг алсын удирдлага ашиглах хэрэглэх ажиллагаанд гарч буй өөрчлөл, шинэчлэл, Братфордын их сургууль/Омега Судалгааны Сан/Алсын Удирдлагын Төсөл, 2015 оны 12 дугаар сар, <https://omegaresearchfoundation.org/sites/default/files/uploads/Publications/Tear%20Gassing%20By%20>
- 37 Эмнести Интернэшнл, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс, Иргэдийн санаа бодлыг үл хүндэтгэн олон нийтийн газруудыг хүчээр хаасан нь, (Индекс: AFR 62/8395/2018), <https://www.amnesty.org/download/Documents/AFR6283952018ENGLISH.pdf>



ГАЗИЙН ЗУРВАСТ НУЛИМС АСГАРУУЛАГЧ ХИЙГ ЗОХИСГҮЙГЭЭР АШИГЛАЖ БАЙГАА НЬ



2018 оны 5 дугаар сарын 14. (Энэ зураг зохиогчийн эрхээр баталгаажсан. © REUTERS/Kenny Katombe)

2018 оны 3 дугаар сараас өрнөсөн эсэргүүцлийн жагсаалын үеэр Израйлийн хүчнийхэн жагсагчдын эсрэг нулимс асгаруулагч хий, резин сумтай буу, болон галт зэвсэг хэрэглэсний улмаас хэд хэдэн хүний амь эрсдэж, хэдэн зуун иргэн хүндээр шархаджээ. Эх нутагтаа эргэн очиж, Израйлийн хууль бус эзлэн түрэмгийллийн эцэст болгох зорилго бүхий энэхүү жагсаалын үеэр Израйлийн талын мэргэн буудагчид болон цэргүүдийн галд 140 орчим Палестин иргэн өртөж нас баржээ. Тэдгээрээс хамгийн багадаа 30 орчим нь хүүхэд, 2 сэтгүүлч, сувилагч болон эрүүл мэндийн ажилтнууд байсан хэмээн мэдээлжээ. НҮБ-ын Хүмүүнлэгийн асуудлыг зохицуулах газраас гаргасан урьдчилсан статистикийн мэдээллээр нийт гэмтсэн иргэдийн тоо 17000 давжээ. Эдгээрээс 9000 орчим нь эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа бөгөөд эдгээрээс 4422 буюу 47 орчим хувь нь өндөр хурдны хүчин чадалтай цэргийн зориулалттай зэвсэгт өртөн шархадсан бол үлдсэн хэсэг нь нулимс асгаруулагч хийг болон резин суманд өртжээ. Израйлийн тал нулимс асгаруулагч харвагч ердийн хэрэгсэл болон хөөргөгч пуужин хэрэглэснээс гадна анх удаа нулимс асгаруулагч хий буудагч дроныг ашиглажээ. Видео бичлэгт Израйльчууд газийн зурвасаас 100 орчим метр зайд байрлах эмнэлгийн тусламж үзүүлэх майхны³⁸ дээрээс дрон ашиглан нулимс асгаруулагч хийгээр буудаж байгааг сэтгүүлчид, жагсагчид зэрэг олон тооны хүмүүс харж байгаа нь авагджээ.³⁹

38 Эмнести Интернэшнл, “Израйль/Сонголт: Израйль/Сонголт: Израйль жагсагчдын эсрэг хүч хэтрүүлсэн хэрэглэх түрэмгийлээ зогсоох шаардлагатай”, 2018 оны 4 дүгээр сарын 13, <https://www.amnesty.org/en/press-releases/2018/04/israelopt-israeli-forces-must-end-the-use-of>

39 Эмнести Интернэшнл, “Израйль/Сонголт: Израйль/Сонголт: Жагсагчдын эсрэг хүч албадлагыг хэтрүүлэн хэрэглэсэн нь. Израйлийн талд олон улсын мөрдөн шалгах хороо холбогдох арга хэмжээ авах шаардлагатай байна, 2018 оны 5 дугаар сарын 18.

4. СУРГАЛТ БОЛОН ТЕХНИКИЙН ЗӨВЛӨГӨӨ

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий хандах явдлыг таслан зогсоохын тулд зөвхөн эрүү шүүлтийн хэрэгслийн худалдааны эргэлтийг үр дүнтэй зохицуулахын зэрэгцээ хууль сахиулагч нарт явуулж байгаа хамгаалах хэрэгслийг хэрхэн хэрэглэх талаарх арга зүйн сургалт, техникийн зөвлөгөөнд анхаарах шаардлагатай. Цагдаа болон хорих ангийн ажилтнуудыг хамгаалах болон хязгаарлах хэрэгслийг хуулийн дагуу хэрхэн хэрэглэх талаарх мэргэжлийн чиглэлийн сургалтуудад хамруулах нь хүний эрхийн хэм хэмжээ, сайн туршлагыг нэвтрүүлэхэд чухал үүрэгтэй. Гэвч нэг бүрийн тусгай хэрэгсэл, тухайлбал бороохойг хүчирхийллийн хэрэгсэл болгон хэрхэн ашиглах талаар хууль сахиулагч нарт сургалт явуулж байсныг Эмнести Интернэшнл болон Омега Судалгааны Сан баримтжуулжээ.⁴⁰ Хэрэв дээрх сургалтыг хүлээн авагч улсын хууль сахиулах албаны өндөр албан тушаалтнууд тухайн аргыг хэрэглэх талаар шийдвэр гаргавал энэ нь хүчирхийллийн эрсдэлийг нэмэгдүүлнэ.

Тиймээс улс орнууд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий хандах явдалтай тэмцэхийн тулд хууль сахиулагч нарт зориулсан аливаа заавар, зөвлөгөө, болон мэдлэг, ур чадвар болгох сургалт зэрэг техникийн ажиллагаанд зохих хяналт тавих шаардлагатай. Ингэснээр хуулиар хориглосон бөгөөд эрүүдэн шүүх, хүнлэг бус, хэрцгий хандах зорилгоор ашигладаг аливаа хэрэгсэл, арга ажиллагаа, ур чадварын талаарх зөвлөгөө, сургалт, ур чадварыг албан хаагчдад олгохгүй байх баталгаа бүрдэх юм. Эцэст нь тэмдэглэхэд хэдийгээр хууль сахиулах зорилгоор ашиглагддаг хэдий ч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий байдлаар хандахад ашиглаж болохуйц хэрэгслийг хэрхэн хэрэглэх талаарх сургалт, техникийн зөвлөгөө явуулахад холбогдох төрийн байгууллагаас зөвшөөрөл авдаг байх тогтолцоог бий болгох шаардлагатай байна.



Зураг. Бороохой ашиглан хүнийг хэрхэн боох талаарх сургалт (бороохой үйлдвэрлэгч компаний вебсайтаас авав)

40 Эмнести Интернэшнл болон Омега Судалгааны Сан, “Хүчин чармайлт: Цаазаар авах ял болон эрүү шүүлтэнд ашиглах хэрэгслийн Европын улс орнууд дахь худалдааг эцэс болгох нь” (Индекс: АСТ 01/1632/2015).

5. ДҮГНЭЛТ

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий хандах явдлыг үндэсний хууль тогтоомжоор хориглон гэмт хэрэгт тооцох нь дээрх хүний эрхийн зөрчилтэй тэмцэхэд хангалттай байж чадахгүй. Улс орнууд энэхүү хүний эрхийн зөрчилтэй тэмцэхийн тулд олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй. Дээрх цогц ажиллагааны нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг нь эрүүдэн шүүх хэрэгслийн худалдааг таслан зогсоож, холбогдох арга хэмжээг тогтмол авч байх явдал юм.

Тийм ч учраас Эмнести Интернэшнл болон Омега Судалгааны сан нь Эрүүдэн шүүх хэрэгслээс ангид худалдааг дэмжих Дэлхийн холбоо байгуулагдсаныг сайшаан дэмжиж байна. Уг холбооны гишүүн улс орнууд эрүүдэн шүүх хэрэгслийн худалдааг хянах үндэсний, бүс нутгийн болон олон улсын эрх зүйн зохицуулалтыг хөгжүүлэх, үр нөлөөтэй хяналтыг тогтолцоог бий болгох талаарх Холбооны зорилгод тодорхойлсон үүргээ биелүүлэхэд хүчин чармайлт гаргах шаардлагатай байна. Эрүү шүүлт болон бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий хандах явдлыг таслан зогсоох олон улсын хүчин чармайлтын нэг хэсэг болохын хувьд бид дараах чиглэлд анхааран ажиллах шаардлагатай.

- **Харгис, хэрцгий бөгөөд хүний эрхийг ноцтой зөрчих зорилгоор ашиглаж байгаа хууль сахиулах үйл ажиллагаанд хэрэглэдэг зэвсэг, тусгай хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа, ашиглалтыг бүрэн хориглох**

Улс орнууд цаазын ял, эрүүдэн шүүлт болон бусад хүнлэг бус, хэрцгий хандах зорилгоор ашигладаг хэрэгсэл болон хуулиар хориглосон бусад хэрэгсэл, түүнчлэн хүний эрхэд ноцтой хохирол учруулж болох бусад хэрэгслийг үйлдвэрлэх, ашиглах, экспортлох, импортлох, тээвэрлэх болон дамжуулан тээвэрлэх явдлыг хориглох шаардлагатай. Эдгээр хэрэгсэлд цахилгаан гүйдлийн нөлөөгөөр шууд хүчтэй цочроох хэрэгслүүд, хүний биед бэхлэн цахилгаан гүйдлээр цохих хэрэгслүүдээс гадна хүнлэг бус, хүчтэй өвтгөх зориулалт бүхий хязгаарлагч хэрэгсэл, тухайлбал гарын эрхий хурууны гав, хөлийн хүндрүүлсэн дөнгө, төмөр сараалж бүхий ор, кинетик нөлөөлөл бүхий зэвсэг, ташуур, өргөст бороохой, хүндрүүлсэн бээлий гэх мэт хамаарна.

- **Хүнийг эрүүдэн шүүх болон хүнлэг бус, хэрцгий хандахад ашигладаг хэрэгслийн худалдааг хянах, хүний эрхэд суурилсан эрсдэлийн үнэлгээг хэрэгжүүлэх шаардлагатай.**

Улс орнууд цагдаагийн байгууллага, хорих газар зэрэг хууль сахиулах байгууллагад ашигладаг гарын гав, бороохой, олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл (нулимс асгаруулагч хийх), цахилгаан гүйдлээр цохигч гэх мэт хэрэгслийн экспорт, импортод хяналт тавих үүрэгтэй. Эрсдэлд суурилсан үнэлгээ нь дараах энгийн дүрэмд үндэслэсэн байвал зохино. Үүнд: хууль сахиулах үйл ажиллагаанд хэрэглэх тусгай хэрэгслийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий хандах зорилгоор ашиглах эрсдэлтэй этгээдэд хэзээ ч ханган нийлүүлж болохгүй.

Эцэст нь тэмдэглэхэд, Эмнести Интернэшнл болон Омега Судалгааны сан дэлхийн бүхий улс орнуудад хандан

- **Тайлагнах, харилцан мэдээлэл солилцох, ил тод тогтолцоог бий болгох замаар эрүүдэн шүүхийн хэрэгслийн худалдааг зохицуулах бүс нутгийн болон олон улсын механизм бий болгохыг уриалж байна.**

**ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ НЬ
ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨХ
ДАЯН ДЭЛХИЙН ХӨДӨЛГӨӨН.
НЭГ Л ХҮНИЙ ЭРХ
ЗӨРЧИГДВӨЛ ЭНЭ НЬ БИД
БҮГДЭД ХАМААТАЙ.**

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Холбоо барих



info@amnesty.org
mongolia.amnesty@gmail.com



+44 (0)20 7413 5500
+976 7000 4708



www.facebook.com/AmnestyGlobal
www.facebook.com/ Amnesty International
Mongolia - Монголын Эмнести Интернэшнл



@AmnestyOnline

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ИНДЕКС: АСТ 30/9039/2018
2018 ОНЫ 9 САР
ХЭЛ: АНГЛИ

amnesty.org

omegaresearchfoundation.org



Omega Research Foundation

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ

